

ШИНЭЖИНС СУМЫН 2024 ОНЫ ЖИЛИЙН ЭЦСИЙН ХҮНИЙ ЭРХИЙН ТӨЛӨВ БАЙДЛЫН ТАЙЛАН

2024 оны 12 дугаар сарын 02

Залаа

1.Хүний эрхийг хангах механикм

Зөв амьдрал дэд хөтөлбөрийн хүрээнд:

Архинд донтох өвчтэй хүн болон архины хамаарлын талаар эрүүл мэнд, сэтгэл зүйн зөвлөгөө өгөх, дэмжлэг үзүүлэх чиглэлээр Монголын үг урлаачдын нийгэмлэгийн тэргүүн, сэтгэл зүйч Г.Бандицэрэн 2025 оны 05 дугаар сарын 13-ны өдөр "Амьдралын үнэ цэнэ" сэдвээр сургалт лекц тавьж 5 гэр бүлд сэтгэл зүйн зөвлөгөө өгч ажилласан. Мөн иргэдийн нийтийн хуралд энэ чиглэлээр мэдээлэл сургалт өгч ажилласан.

Аймгийн Хүүхэд гэр бүлийн хөгжил хамгааллын газраас 4 дүгээр сард нэг удаа Хүүхэд хамгааллын эрх зүйн орчны шинэчлэл, үе тэнгийн дээрэлхэлт, өвсөр үеийн охидын эрүүл мэнд зэрэг сэдвүүдээр, нийгмийн бодлогын мэргэжилтэнд кейс бүрдүүлэлтийн чиглэлээр сургалт зөвлөгөө өгч ажилласан. Мөн аймагт болсон Монгол өрх сэтгэл зүйн нийгэмлэгээс зохион байгуулсан Кейс дээр ажиллах арга зүй, хүүхдийн сэтгэл зүйн онцлог чиглэлээр сургалтад сургуулийн нийгмийн ажилтан, нийгмийн бодлогын мэргэжилтэн нар хамрагдсан

Гэр бүл дэхь архины хамааралтай гишүүдийг эмчлэх, нөхөн сэргээх ажлыг эрчимжүүлэх тухай" аймгийн Засаг даргын 2024 оны А/311 дүгээр захирамжийг хэрэгжүүлэх үүднээс тус сумын 4 багийн засаг дарга, цагдаагийн хэсэг, эрүүл мэндийн төвөөс судалгаа авч нэгтгэн ажилласан байна.

- Зорилтот өрхийн болон өрх толгойлсон эцэг, эхийн нийгмийн баталгааг хангах, Хөдөлмөр эрхлэлтийг дэмжих:

Иргэнд санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээний талаар иргэдэд мэдээлэл хүргэж 1 иргэний төслийг ХХҮГ-т хүргүүлсэн. - Уул уурхайн Эрдэнэмонгол ХХК-ны "Баян хөндий төсөл"-ийн талбайд 7 иргэнийг ажиллуулан түр ажлын байраар хангасан. Нийгмийн халамжийн тэтгэвэр, тэтгэмж, хөнгөлөлт тусламжинд давхардсан тоогоор 322 иргэнд 227 сая орчим төгрөг зарцуулсан. Малгүй болон цөөн малтай малчин өрхийг малжуулах санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээнд 8 өрхийн материалыг хүргүүлсэн. Гарааны бизнес эрхлэгч залуучуудад санхүүгийн дэмжлэг олгох үйлчилгээний зарыг цахим сайтад байршуулсан.0-3 хүртэлх насны хүүхэд асарсны тэтгэмж 107 иргэнд 26451585 төгрөг, Өрх толгойлсон эх, эцэгт олгох

тэтгэмж 9 иргэнд 5512088 төгрөг, Жирэмсэн эхийн тэтгэмж 12 иргэнд 2411123 төгрөг ажилласан. Хүүхдийн мөнгөн тэтгэмжинд 1011 хүүхдэд 517 сая төгрөг олгож ажилласан.

ХБИ-ын дунд софт волейболын тэмцээн, даам, шатарын тэмцээн зохион байгуулан ажиллаа. Софт волейболын тэмцээнд нийт 7 баг буюу 28 хүн оролцлоо. Мөн хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн эрх үүргийн талаар ХБИ-ийн хөтөлбөр хариуцсан эмч Д.Нямцэрэн сургалт хийж мэдээлэл өгсөн. Сургалтанд 17 иргэн хамрагдсан.

Ажил хайгч иргэнээр 21 иргэнийг бүртгэсэн. -Ажлын байрны бүртгэлд 2 аж ахуйн нэгжийг бүртгэсэн -Ажлын байрны 25 захиалга бүртгэсэн Түр ажлын байранд 7, байнгын ажлын байранд 15 иргэн нийт 22 иргэнийг бүртгэж мэдээллийн санд оруулсан.

- Залуучуудын хөгжлийг дэмжих ажлын хүрээнд:

Сумын залуучуудын хөгжлийн салбар зөвлөл нь залуусын хамтын ажиллагаа, хөгжил, нийгмийн идэвх оролцоог нэмэгдүүлэх зорилгоор 2024 оны үйл ажиллагааны төлөвлөгөөг боловсруулан ажиллаа. Залуучуудын хөгжлийн салбар зөвлөлийн ажлын эрчимжүүлэх талаар хурал хийж, 2024 оны 04 сарын 24-ний А/44 дүгээр захирамжаар салбар зөвлөлийг шинэчлэн байгуулж, төлөвлөгөөг гаргаж батлууллаа.

Өсвөр насны хүүхдийн эрүүл мэндийн боловсорлыг нэмэгдүүлэх ажлын хүрээнд:

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдөрт зориулан нээлттэй өдөрлөг зохион байгуулсан. Өдөрлөгөөр илтгэлийн уралдаан, чуулган, спортын тэмцээн, нэг цэгийн үйлчилгээ, өсвөр насны охидуудад зориулсан сургалт зэрэг олон үйл ажиллагааг зохион байгуулсан. Сургалтыг 7-9 ангийн нийт 46 сурагчдад сумын Эрүүл мэндийн төв болон ЕБС-ийн эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Өдөрлөгийг сумын албан ёсны цахим хуудас болох Шинэжинст ЗДТГ фэйжээр лайв хэлбэрээр давхар зохион байгуулж ажилласан.

Хүүхдийн эрхийг хамгаалах чиглэлээр:

Сургууль, эцэг эх асран хамгаалагч нарын уялдаа холбоог сайжруулах зорилготой уулзалт өртөөчилсөн сургалт зохион байгуулж нийт 190 эцэг эх асран хамгаалагч оролцсон. ГБХЗХХ-ийн газрын хүмүүжлийн эерэг арга сургалт 2 удаа эцэг асран хамгаалагч нарт орсон. Нийт 220 эцэг эх хамрагдсан. Эрүүл мэндийн

шалтгаанаар сургуулийн гадна 2 хүүхэд байдаг. Энэ 2 хүүхдэд ганцаарчилсан сургалтын төлөвлөгөөгийн дагуу НТСНБагш сард нэг удаа асран хамгаалагч нартай хамтарч өөрийн сэтхүй онцлогт нь таарсан бие даалтыг өгч ажилдаг. Энэ 2 хүүхэд хэвтрийн тул биеэ даах чадвар байхгүй. Сурагчдын дунд Аутизм, Усны өдрийн постерийн уралдаан, Авлигын эсрэг гэрэл түгээе аянг тус тус амжилттай зохион байгуулан шагнал байранд шалгарсан сурагчдыш шагнаж урамшуулсан нийт 53 сурагч оролцсон. Сар бүрийн сүүлийн долоо хоногийг багш айлчлалын долоо хоног болгон зарлаж Анги удирдсан багш нар нийт сурагчдын 70% аар айлчлал хийн сурагчдын амьдрах орчин, эрүүл аюулгүй орчинд хичээл хийх таатай орчин бүрдсэн талаар судлан ажиллаж байна. Сургуулийн хүүхэд хамгааллын багаас сумын Хамтарсан багт өрх толгойлон амьдарч буй сурагчид, гэмт хэрэгт өртөж болзошгүй сурагчдын судалгаа гарган өгч Сумын хамтарсан баг оройн 19:00 цагаас 22:00 цаг хүртэл эргүүлд гаран ажиллаж байна. Хүүхэд хамгааллын баг нэг өргөдөл хүлээн авч шийдвэрлэсэн Мөн сумын Хамтарсан багт өрх толгойлон амьдарч буй сурагчид гэм хэрэгт өртөж болзошгүй 12 сурагчдын судалгааг гарган өгч оройн цагаар гэр айлчлал хийн ажилласан. Хүүхдээ сонсох өдрийг улиралд нэг удаа зохион байгуулж сурагчид тулгамдаж буй асуудлын талаар судалгаа гарган Сумын хамтарсан багт хүргэн ажилладаг. Хүүхдийн чуулганыг нэг удаа зохион байгуулж Сумын хамтарсан багийн ахлагч Б.Бат-Эрдэнэ, Сумын нийгмийн бодлогын мэргэжилтэн Ш.Даваацэрэн нар оролцож Хүүхдийн эрх, соёл спорт олон нийтийн ажилд оролцох журмын талаар мэдээлэл өгсөн нийт 120 сурагч оролцсон.

2.Хүний эрхийн суурь эрхийг хангасан үйл ажиллагаа

Эрүүл мэндийн байгууллагаас хүнийг эрхийг хангах чиглэлээр хийсэн үйл ажиллагаа:

Хөгжлийн бэрхшээлтэй иргэдийн дунд дараах үйл ажиллагааг зохион байгууллаа. Хүний эрх, эрх зүйн талаар сургалт хийж мэдээлэл хийсэн. Сургалтанд нийт 26 иргэн хамрагдсан. Мөн уралдаан тэмцээнийг зохион байгуулж хамтран ажилласан.

Үүнд: ХБИ-ын дунд хөгжөөнт буухиа тэмцээн, дардасны тэмцээн зохион байгуулан ажиллалаа. Хөгжөөнт буухиа тэмцээнд нийт 13 хүн оролцсон. Тэмцээн өрсөлдөөнтэй сайхан болж өндөрлөсөн. 1-р байранд Д.Баярэрдэнэ, 2-р байранд Х.Болормаа, 3-р байранд В.Төмөрчөдөр нар тус тус байр эзэлсэн.Тэмцээний шагналт байранд орсон иргэдийг алт, мөнгө, хүрэл медаль өргөмжлөл, дурсгалын зүйлээр шагнаж урамшуулсан.

Ахмад настанууд:

Ахмад настны эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд шинэжинст сумын ахмад настангуудын дунд эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэг оношилгоо хийж, эм, витамин зөв зохистой хэрэглээ, сэдвээр сургалт хийлээ. Дасгал хөдөлгөөн хийлгэж эрүүл мэндийн зөвлөгөө өгсөн. Нийт 75н ахмад настан эрүүл мэндийн үзлэгт хамрагдсан байна. Урьдчилан сэргийлэх үзлэгт ирсэн ахмадууддаа буцалгасан аарц, чацарганы шүүс өгсөн. Багийн эмч, эмчлэгч эмч, болон эх баригч нар артерийн даралт, биеийн өндөр, жин үзэж, үзлэгийн бүртгэл, хөтлөж ажилласан. Ахмадын биеийн өндөр жинг үзсэн мөн эмийн зөв зохистой хэрэглээ сэдвээр гарын авлага боршур бэлдэж, тарааж ажиллалаа. Сургалтын үеэр өндөр настангуудад амны маск болон витамин, хайрцагтай вакуус, өгч дархлааг нь дэмжсэн. Мөн эрүүл мэндийн төвд ажиллаж байгаад өндөр насны тэтгэвэртээ гарсан 8 ахмадад эмнэлгийн зүгээс гарын бэлэг болох дархлаа дэмжих бэлдмэл өгсөн. Ахмадын эрүүл мэндийг дэмжих ажлын хүрээнд ахмад настны дунд дараах ажлуудыг өртөөчилсөн байдлаар явууллаа.

1-р өртөө Бүртгэлийн хэсэг

2-р өртөө Эмчийн үзлэг

3-р өртөө Артерын даралт үзэх

4-р өртөө Витаминжуулалт

5-р өртөө Дасгал хөдөлгөөн гэсэн 5 өртөөг ажиллууллаа. Эмчийн үзлэгээр шаардлагатай хүмүүсийг шинжилгээнд хамруулсан. Лаборант Д.Даарий ахмадын дунд “Элэг бүтэн монгол” хөтөлбөрийн хүрээнд элэгний В,С вирусын талаар мэдээлэл өгч, дасгал хөдөлгөөн хийлгэж биеийн чилээг нь гарган эмч сувилагч нар хамтдаа хийлээ. Мөн танин мэдэхүйн АХА тэмцээнийг ахмадын дунд зохион байгуулж шагнаж урамшууллаа. 1-р байранд ахмад настан Н.Загдаа, 2-р байранд Ц.Төмөрбат, 3-р байранд Х.Болормаа нар тус тус орлоо.

Жирэмсэн эмэгтэйчүүд:

Жирэмсэн эмэгтэйчүүдийн дунд эх баригч Д.Бадамсүрэн эрүүл зөв хооллолт, жирэмсэн үеийн хооллолт, төмрийн хэрэглээ, жирэмсэний эрт үеийн хяналт сэдвүүдээр сургалт хийж мэдээлэл өгсөн. Сургалтанд 31 жирэмсэн хамрагдсан. 1-3 сартай жирэмсэн эмэгтэйчүүдэд жирэмсэний хордлогын талаар мэдээлэл хийсэн. Нийгмийн эрүүл мэндийн ажилтан гарын авлага боршур бэлтгэн тарааж ажиллалаа.

3-5 насны хүүхдүүдийн дунд “Томуу томуу төст өвчин Амны хөндийн эрүүл мэнд” сэдвүүдээр бага эмч Х.Даваа сургалт хийж мэдээлэл өгсөн. СӨБ-ын 2-5 насны хүүхдүүдэд урьдчилан сэргийлэх үзлэг хийж зөвлөгөө өгсөн. 6-59 сартай хүүхдүүдэд эрүүл мэндийн төвөөс “А” амин дэм өгсөн.

Зорилтот бүлгийн 10 хүнд дархлаажуулах багц өгч, ар гэрийн асран хамгаалагч нарт асаргаа сувилгаа болон халамжийн хуулийн эрх зүйн мэдлэгийн боловсрол олгож,гэрээр зөвлөгөө өгсөн.

ЕБС-ийн бүтэн өнчин болон хагас өнчин охидуудад ЭМТ-ийн дарга Б.Хоролмаа нийгмийн ажилтан И.Ууганбаяр нар сурагчдын дотуур байранд очиж нөхөн үржихүйн хууль эрх зүйн боловсролыг олгож ариун цэврийн болон ахуйн хэрэглээний хэрэгсэлийг байрын багш Б.Ариунжаргалд хүлээлгэн өгсөн.

Зорилтот бүлгийн харааны бэрхшээлтэй 3-р багийн иргэн Жинжиймаагийн ар гэрт нь очиж урьдчилан сэргийлэх үзлэг хийж, 0-3 насны хүүхдүүдэд нь дархлаажуулах багц өгч тухайн ээжид нь ариун цэврийн хэрэгсэл өгсөн.

Ард иргэдийн дунд:

Ард иргэдийн дунд болон албан байгууллага аж ахуй нэгжүүдээр эрүүл мэндийн боловсрол олгох сургалт сурталчилгаа мэдээ мэдээлэлийн ажлыг үр дүнтэй зохион байгуулж байна. Сургалтыг танхимын болон цахимын гэсэн хоёр төрлөөр явуулж иргэдэд мэдээлэл өгч байна. Танхимын сургалтыг хуваарын дагуу жилд 45 удаагийн сургалт зохион байгуулахаар төлөвлөөд байна.Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн сурагчдын дунд Томуу томуу төст өвчин, Электрон тамхины хор уршиг түүний нөлөө,Нөхөн үржихүйн эрүүл мэнд, Дэлгэцийн донтолт, Амны хөндийн эрүүл мэнд, Эмийн зохистой хэрэглээ, Эрүүл зөв хооллолт, зэрэг сэдвүүдээр сургалт зохион байгуулж сургалтын өмнөх болон дараах сорилыг авахад 75% байсан бол 85-90% болж нэмэгдсэн үр дүнтэй. Сургалтанд 50-70 хүүхэд хамрагддаг сургалтын үр дүн 95%-тай байна.

Иргэдийн дундах давсны хэрэглээг бууруулах зорилгоор эмнэлгийн ажилчид болон ард иргэдийн дунд “Давсаа хасъя” сэдвээр сургалт хийж гарын авлага тараасан. Сургалтанд нийт 63 хүн хамрагдаж давсны хэрэглээний талаар санаа бодлоо солилцлоо. Арга хэмжээнд оролцсон иргэдийн бүртгэл хийж, сургалтын үеэр мандалгоо эмийн сан амны маск, витамин тараалаа.

Мөн эмчилгээний хоолны амталгаа явагдаж эрүүл мэндийн төвийн эмч нар тухайн хоолны талаар зөвлөгөөг иргэдэд өгөв. Артерийн даралт, таргалалт, бөөр, элэг цөс

нойр булчирхай, ходоод, зүрх судас, гэсэн өвчлөлийн үед идэж болох хоолнуудыг бэлтгэж өдөрлөгт ирсэн иргэдэд зөвлөгөө мэдээлэл өгч ажилласан.

Статистикч бага эмч Д.Нямцэрэн артерийн даралт ихсэх өвчний үед идэх хоол хүнсний талаар зөвлөгөө мэдээлэл хийсэн. Бага эмч Х.Даваа хориотой хүнсний бүтээгдэхүүний талаар иргэдэд сургалт хийж мэдээлэл өгөв. Мөн эдгээр бүтээгдэхүүнд ямар хэмжээний давс болон сахар ордог, өргөн хэрэглээний хүнсний шошгийг яаж таньж мэдэх зэрэг олон төрлийн зөвлөгөөг нийгмийн эрүүл мэндийн ажилтан өгсөн.

Хуванцар савны хэрэглээ:

06 дугаар сарын 05 ны өдрийг Дэлхийн хүрээлэн буй орчны өдөр болгон жил бүр тэмдэглэн ирсэн билээ. Энэ өдрийн хүрээнд ард иргэдийн дунд "Хуванцар савны хэрэглээ" сэдвээр сургалт хийж мэдээлэл, зөвлөгөө өгсөн. Хүмүүс ихэвчлэн хоол хүнснийхээ хэрэгцээнд хуванцар савыг түгээмэл хэрэглэж байгаа тул иргэдэд тэр дундаа айл гэрийн эзэгтэй нарт энэхүү сургалт сурталчилгаа мэдээлэлээ хүргэж ажиллахыг илүүд үзлээ. Одоо үед хуванцар саваар дамжиж маш олон төрлийн өвчин гарч байгаа тул хуванцар савыг хэрэглэж болохгүй түүний хор нөлөө их байдаг гэдгийг мэдээлэлээрээ дамжуулан хэлсэн. Сургалтанд нийт 71 иргэд хамрагдсан. Сургалтанд суусан иргэдэд гарын авлага тарааж сургалтын дараа хуванцар савны тухай видео шторк үзүүлсэн. Мөн эрүүл мэндийн төвийнхөө эмч, ажилтандаа "Хуванцар савны зохисгүй хэрэглээ" сэдвээр сургалт мэдээлэл хийлээ. Сургалтанд 22-19 эмч ажилтан хамрагдаж гарын авлага зурагт хуудас тараасан.

Ихэвчлэн айл өрхүүд ундны усаа хуванцар саванд хийдэг нь хоол боловсруулах эрхтэн болон бусад эрхтэн системийг гэмтээж түүнээс болж ходоод дотор нь өвддөг билээ. Ходоод дотор өвддөг хэдэн хүн байна гэхэд 3 хүний 2 нь ходоод өвддөг гэж хариулсан. Сүүлийн үед хуванцар савны хэрэглээ маш их ихсэж байгаа усны сав, хоолны сав, тэр ч бүү хэл нярай хүүхдийн угжны сав хүртэл хуванцар материалаар хийгдэж байгаа нь харамсмаар зүйл билээ. Иргэдэд хийсэн сургалтан дээр хүмүүс хоорондоо санаа бодлоо солилцож нэгнийгээ хуванцар савныхаа хэрэглээг багасгахыг хүртэл уриалж байлаа. Айлаар орж хуванцар савны талаар асууж тодруулахад олон биш ч 1-2 хуванцар сав, шанага гэх зүйлийг байнга хэрэглэж байгаа гэж хариулж байсан. Иргэдэд хуванцар савны талаар зөвлөгөө мэдээлэл өгч 14 хоногийн дараа эргэн ирж үзэхээр болсон. Товлосон хугацаанд айлуудаар ортол хуванцар савны хэрэглээгээ өргөн хэрэглээнээсээ хассан сайн мэдээтэй сууж байсан. Сумын нийт өрхийн 10% ч болтугай хуванцар савнаас татгалзаж чадсан

байна. Хуванцар савны хэрэглээ сэдвээр гарын авлага бэлтгэн хийж иргэдэд нийт 326ш тарааж ажилласан.

Нийгэм, соёлын эрх:

Иргэдийн эрх зүйн мэдлэгийг дээшлүүлэх, зөвлөгөө тусламж өгөх зорилгоор Долоо хоног бүрийн Даваа гарагт иргэдийн “Мэдээллийн цаг”-ийг 2024 оны 12 дугаар сарын 02-ний өдрийг хүртэл зохион байгуулсан. Мэдээллийн цагаар албан байгууллагын захирал, дарга, эрхлэгч болон төрийн албан хаагчид өөрсдийн ажил мэргэжлийн онцлогоос хамаарч шинэчлэгдсэн болон иргэдэд хэрэгтэй хууль тогтоомж, зөвлөгөө мэдээллийг нийт 15 удаагийн сургалт, 1 АХА тэмцээн, Үндсэн хууль батлагдсаны 100 жил, ардчилсан Үндсэн хууль батлагдсаны 32 жилийн ой болон Татварын тухай хуулийн талаар АХА тэмцээнийг Авто тээврийн үзлэгийн өдөр буюу 05 дугаар сарын 07-нд нийт 50 иргэдийн дунд зохион байгуулсан. Мөн Эрүүгийн болон Зөрчлийн тухай хууль, Хүний эрхийн тухай, Гэмт хэргийн тухай, Үндсэн хуулийн талаар нийт 200 ширхэг гарын авлага хийж, байгууллагын дарга нартай биечлэн уулзаж, хууль эрх зүйн чиглэлээр 2024 онд хийгдэх ажлуудын төлөвлөгөөг танилцуулж, хамтран ажиллах талаар уулзалт хийж 10 ширхэг гарын авлагыг тус тус тарааж өгсөн. 100 ширхэг гарын авлагыг Тээврийн үзлэгийн үеэр иргэдэд тарааж ажилласан. Гарын авлагыг хүүхэд болон том хүнд зориулсан байдлаар хүргэсэн.

1. Шинэжинст сумын “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил”-ийн нээлтийн арга хэмжээ, эмэгтэйчүүдийн манлайлал, оролцооны чиглэлээр:

Хүүхэд, гэр бүлийн хөгжил, хамгааллыг сайжруулж, аливаа хүчирхийлэл, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх, хүүхдийн сурч хөгжих, амьдрах, төлөвших ая тухтай орчныг бий болгох зорилгоор Аймгийн Засаг даргын 2023 оны сарын өдрийн тоот захирамжаар 2024 оныг “Гэр бүлийн хөгжлийг дэмжих жил” болгон зарласан. Тус жилийн ажлын төлөвлөгөөг танилцуулж, гэр бүлд боловсрол олгох, хууль эрх зүйн сургалт, мэдээлэл өгөх арга хэмжээг 2024 оны 03 дугаар сарын 01-ний өдөр зохион байгууллаа.

Арга хэмжээнд нийт 54 гэр бүл хамрагдан Сумын Засаг даргын тамгын газрын дарга Л.Батхуяг нээж үг хэлж манлайлагч Залуу гэр бүл Л.Бэгзсүрэн, Г.Буянхишигт, Х.Доржсамбуу нарын гэр бүлд Талархал, урамшуулал гардууллаа. Мөн Соёлын төвөөс арга хэмжээнд оролцож буй гэр бүлүүдэд ая дууны мэндчилгээ дэвшүүлсэн.

“Гэр бүлийн хөгжлийн жил”-ийн хүрээнд сумын хэмжээнд зохион байгуулах ажлын төлөвлөгөөг танилцуулж хамтарсан багийн гишүүн нэгдүгээр багийн Засаг

дарга Д.Энхдалай “Гэр бүлийн тухай хууль”-ийн товч танилцуулгыг хийсэн. Мөн сумын Цагдаагийн хэсгийн төлөөлөгч Б.Баасанжаргал “Гэр бүлийн хүчирхийллийн эсрэг хууль”-ийн талаар товч танилцуулгыг хийж анхаарах асуудлуудыг танилцууллаа. Арга хэмжээнд оролцогчдын дунд АХА тэмцээн зохион байгуулж сургалт мэдээллийн хүрээнд олж авсан мэдлэгийг шалгасан. Тус тэмцээнд 1-р байранд Ерөнхий боловсролын сургуулийн багш Д.Ганболор, 2-р байранд Г.Мандах, 3-р байранд У.Мөнхнаран нар тус тус шалгарч шагнаж урамшууллаа.

11 сарын 11-ны мэдээллийн цагаар Хамтарсан багаас Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, эцэг эх хүүхдийн харилцаа хандлага, полипама вирусын эсрэг вакцин, төрийн албан хаагчийн ёс зүй зэрэг сэдвүүдээр сургалт мэдээлэл хийсэн. Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр үсчин гоо сайхан, талх нарийн боов, хоол үйлдвэрлэл эрхлэгчдийн төлөөллөөр “Нэг цэгийн үйлчилгээ” гаргаж ард иргэдэд сурталчилах, үйлчлэх арга хэмжээ зохион байгуулсан. 6 өрхийн үйлдвэрлэл эрхлэгчид оролцсон.

ХАА-н тасагтай хамтран өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нарын дунд “Өрх бүр үйлдвэрлэгч” уралдаант үзэсгэлэн худалдаа арга хэмжээг амжилттай зохион байгуулж, 4 төрөлд шалгаруулан шагнаж урамшуулсан. Өрхийн үйлдвэрлэл эрхлэгч нарын бүтээгдэхүүн үйл ажиллагааг сурталчилан таниулах, дэмжлэг үзүүлэх тус арга хэмжээнд нийт 16 өрхийн гишүүд хамрагдсан. Тус арга хэмжээнд төсвөөс 1000.000 төгрөг зарцуулсан.

Олон улсын эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрийг угтан 2024 оны 03 дугаар сарын 06-08-ны өдрүүдэд сумын нийт эмэгтэйчүүдийн дунд “Эмэгтэйчүүдийн оролцоо, манлайлал, хамтын ажиллагаа” илтгэлийн уралдаан, чуулган хэлэлцүүлгийг сумын Эмэгтэйчүүдийн зөвлөлтэй хамтран зохион байгууллаа. Чуулганаар сум, орон нутгийн эмэгтэйчүүдийн өмнө тулгамдаж буй асуудлуудыг төрийн албан хаагч эмэгтэйчүүд, хувиараа болон бизнес эрхлэгч эмэгтэйчүүд, малчин эмэгтэйчүүдийн төлөөллөөс багцалсан саналуудыг хэлэлцүүлж нэгтгэлээ. Тус чуулганд сумын ИТХ-ын дарга Н.Жаргалсайхан оролцож эмэгтэйчүүдийн санал бодлыг сонсож цаашид тус асуудлуудыг ажил хэрэг болгож хамтран ажиллахаа илэрхийллээ.

Мөн сум орон нутагтаа олон жил ажиллаж хөдөлмөрлөн нийгэмд гүйцэтгэсэн үүрэг, ажил хөдөлмөрөөрөө манлайлж, үр хүүхдүүдээ зөв үлгэр дуурайлалтай иргэн болгон төлөвшүүлсэн есөн эрдэнийн бэлэгдсэн есөн ээжүүдийг алдаршуулан өргөмжилж, алдар, гавьяа амжилт бүтээлийг нь сурталчлан таниулав.

Хүүхдийн эрхийн улсын байцаагчийн 2024 оны 02 сарын 02 –ны өдрийн 01 дугаар зөвлөмжийг хэрэгжүүлж ажилласан талаар:

Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолыг эцэг эх, асран хамгаалагч, иргэд олон нийт, уяачдад сурталчлан таниулах үүднээс дараах арга хэмжээг авч ажиллалаа. Үүнд:

1. Сумын Засаг даргын 2024 оны 02 дугаар сарын 07-ны өдрийн А/08 дугаар захирамжаар сум, орон нутгийн хэмжээнд өвөл, хаврын улиралд хурдан морины уралдаан, үсэргээ, сунгаа зохион байгуулахыг 2024 оны 05 дугаар сарын 01 хүртэл хориглож холбогдох мэдээллийг багийн засаг дарга нар болон сумын “Залаажинстийн хурд” уяачдын холбоонд хүргэсэн.

2. Энэ хугацаанд албан ёсоор орон нутгийн хэмжээнд хурдан морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахаар хандсан иргэд, байгууллага байгаагүй. Наадмаар зохион байгуулсан уралдааны 28 уралдаанч хүүхдийг системд бүртгэж, уралдаанч хүүхдүүдийн аюулгүй байдлыг хангаж ажилласан.

3. Зөвшөөрөлгүй уралдаан, сунгаа үсэргээ зохион байгуулахгүй байхыг, хууль тогтоомжийг биелүүлээгүй зөрчсөн тохиолдолд холбогдох хууль журмын дагуу хариуцлага тооцохыг анхааруулсан албан тоотыг холбогдох баг, байгууллагад хүргэж ажилласан.

Баянхонгор аймгийн Цагдаагийн газраас ирүүлсэн 31 дугаар зөвлөмжийн дагуу хийсэн ажлын тухай:

1. Засгийн газрын 2019 оны 57 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх үүднээс 2024 оны 05 сарын 01 хүртэл морины уралдаан, сунгаа, үсэргээ зохион байгуулахыг хориглох тухай Сумын Засаг даргын А/08 тоот захирамжийг гаргаж нийт ард иргэд, уяачдын холбоонд хүргэж танилцуулсан.

2. Нийт байгууллагууд болон багийн Засаг дарга нарт зөвлөмжийг хэрэгжүүлж ажиллах талаар албан бичиг хүргүүлэн зөвлөмжийн хүрээнд хийсэн ажлын тайланг авч нэгтгэсэн. Үүнд: Ерөнхий боловсролын сургууль:

1. Дотуур байрын 55 сурагчдыг гараас гарт хүлээлгэн өгч холбоо барих дугаарыг тэмдэглэн эцэг эх асран хамгаалагчийн гарын үсгээр баталгаажуулсан.

2. Хүүхдээ мал аж ахуйн ажилд туслуулахдаа цаг агаарын нөхцөл байдлыг харгалзан хонинд явуулах бага насны хүүхдийг харгалзах хүнгүйгээр гэртээ орхихгүй байх талаар зөвлөмж постер бэлтгэж олон нийтийн мэдээ мэдээллийн хэрэгслэлээр дамжуулан хүргэсэн.

3. Баярын өдрүүдэд хүүхдийн ахуйн болон бусад осол гэмтлээс урьдчилан сэргийлэх постер мэдээ мэдээлэл хүргэсэн.

Мөн бага насны хүүхдээр хурдан тэмээ, адуу унуулахгүй байх зөвлөмжийг эцэг эх асран хамгаалагч нарт цахим сүлжээгээр хүргэн ажилласан.

Сар шинийн баярын өдрүүдэд анхаарал, сонор сэрэмжээ бүү сулруулаарай, нохойгоо бат бэх уяагаар уях, бага насны хүүхдийг хараа хяналтгүй гадаа тоглуулахгүй байх, хашаа, хороог зай завсаргүй бүрэн бүтэн байлгах зэрэг зөвлөмжийг сумын цахим хуудсанд байршуулсан байна.

Гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлж ажиллах ажлын төлөвлөгөөнд 6 арга хэмжээний хүрээнд 14 ажил тусган хэрэгжүүлж ажиллалаа.

1. Сумын хэмжээнд бүртгэгдсэн гэмт хэрэг, зөрчлийн мэдээлэлд дүн шинжилгээ хийж, өсөлттэй байгаа гэмт хэрэг, зөрчлийн шалтгаан нөхцөлийг тогтоож бууруулах, урьдчилан сэргийлэх чиглэлээр сумын Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран хөдөөгийн багийн Иргэдийн нийтийн хуралд 3 удаа, сумын хэмжээнд өсөлт ихтэй байгаа цахимаар залилах гэмт хэргийн талаар сургалт мэдээллийг өгч гарын авлага, тараах материалыг давхардсан тоогоор 210 орчим иргэнд тарааж олон нийтийн цахим сүлжээгээр мэдээллийг тогтмол түгээн ажиллаж байна.

2. Төрийн албан хаагчид тэр дундаа төрийн үйлчилгээний албан хаагчид зөрчилд холбогдох асуудал ихээр гарч байгаа тул төрийн албан хаагчидруу чиглэсэн сургалт, нөлөөлөл, соён гэгээрүүлэх арга хэмжээг зохион байгуулж, үр дүнг тооцох чиглэлээр согтууруулах ундааны эргэлтэд хяналт тавих, архидан согтуурахтай тэмцэх тухай хуулийн талаарх сургалтад онлайнаар согтууруулах ундааны тусгай зөвшөөрөлтэй 16 аж ахуй нэгжүүдийг хамруулсан.

Зөрчлийн тухай хууль, Замын хөдөлгөөний аюулгүй байдлын тухай хууль, Зөвшөөрлийн тухай хуулийн талаарх сургалтыг цагдаагийн ахлах ахлагч Д.Балжинням 04 дүгээр сарын 14-ний өдөр Мэдээллийн цагаар 89 иргэд, төрийн албан хаагчид орсон. Аймгийн шүүхийн тамгын газартай хамтран ажиллаж Шүүхийн иргэдийн төлөөлөгчдийн эрх зүйн байдлын талаар сургалт хийгдэж нийт 8 иргэнийг танхимаар, 2 иргэнийг онлайнаар хамрагдуулсан. Төрийн албан хаагчийн ёс зүйн тухай хуулийн сургалтыг ЗДТГ-ын албан хаагчдад 2 удаагийн сургалтаар орлоо.

3. Гудамж талбайд үйлдэгдсэн гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр эргүүл, хяналт шалгалтыг эрчимжүүлэх, нийтийн эргүүлийн чанар хүртээмжийг сайжруулах чиглэлээр сумын хэмжээнд үйл ажилагаа явуулж байгаа Төрийн болон төрийн бус байгууллага аж ахуйн нэгжүүдийн хяналтын камерыг сайжруулах чиглэлээр сумын ГХУСАЗСЗ-тэй хамтран мэдэгдэлийг хүргүүлж камерийн хяналт тодорхой хэмжээнд сайжирсан бөгөөд Сумын ИНХ-аар

хэлэлцүүлж сумын хэмжээнд хяналтын камерыг нэмэгдүүлэх зорилгоор 20.000.0 сая төгрөгийг шийдвэрлүүлж мэргэжлийн байгууллагаар гүйцэтгүүлэхээр гэрээ, хэлцэл хийгдэн явагдаж байна.

4.Бэлгийн эрх чөлөөний халдашгүй байдлын эсрэг гэмт хэргээс урьдчилан сэргийлэх арга хэмжээ зохион байгуулах, холбогдох мэргэжлийн байгууллагатай хамтран ажиллах чиглэлээр сумын Эрүүл мэндийн төв, Хамтарсан багтай хамтран Ерөнхий боловсролын сургуулийн ахлах ангийн нийт 85 хүүхдэд 3 удаагийн сургалтыг орж мэдээлэл хийсэн.

Энэ төрлийн Гэмт хэрэг зөрчилөөр урьдчилан сэргийлэх зорилгоор мэргэжлийн байгууллагаас цахимаар гаргаж байгаа анхааруулга, шторк, мэдээллийг сумын хэмжээнд идэвхитэй ашиглагдаж байгаа грүпүүдэд түгээж олон нийтийн арга хэмжээнүүдэд цаасан хэлбэрээр тарааж ажилласан.

5. Хулгайлах гэмт хэрэг, зөрчлөөс урьдчилан сэргийлэх чиглэлээр хөршийн холбоо байгуулах, тодорхой ажил арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр хулгайлах ГХУС зорилгоор хөршийн холбоо байгуулах чиглэлээр багийн Иргэдийн нийтийн хурлуудад мэдээллийг хүргэсэн цаашид байгуулах чиглэлээр судалгааг хийж байна. Энэ төрлийн ГХУС зорилгоор багийн ИНХ-д болон сурагчдад мэдээллийг 5 удаа сургалтаар орсон байна.

6. Насанд хүрээгүй хүнийг болзошгүй эрсдэлээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сурагчид, эцэг эх, асран хамгаалагч, харгалзан дэмжигч нарт чиглэсэн нөлөөллийн онцлог ажил, арга хэмжээ зохион байгуулах чиглэлээр Аймгийн "Цахим үйлчилгээний Хэлтэс"-ийн мэргэжилтнүүдтэй хамтран сумын төрийн албан хаагчид болон Ерөнхий боловсролын сургуулийн сурагчдад сургалт мэдээллийг өгсөн бөгөөд сумын ГХУСАЗСЗ, хамтарсан багийн гишүүдийн хамт сургалтыг 3 удаа орж мэдээлэл хүргүүлсэн.

Гэр бүлийн хүчирхийлэл болон гэр бүлийн хүмүүжил насанд хүрээгүй хүүхдийн эсрэг гэмт хэрэг, зөрчилөөс урьдчилан сэргийлэх зорилгоор гэр бүлийн хүчирхийлэл үйлддэг болон үйлдэж болзошгүй этгээдүүдийн судалгааг багийн засаг дарга нартай хамтран гаргаж энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил үйлддэг 6 иргэнтэй уулзалтыг зохион байгуулж энэ төрлийн гэмт хэрэг, зөрчил дахин үйлдэхгүй байхад анхааран ажиллаж байна.

Шинэжинст сумын "гэр бүлийн хөгжлийг дэмжих жил"-ийн хүрээнд гэр бүлд боловсрол олгох сургалт, оны онцлох гэр бүл шалгаруулах уралдаан зохион байгуулсан талаар:

Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн үйл ажиллагааны төлөвлөгөөнд тусгасны дагуу Хамтарсан багийн санаачлагаар Монголын үг урлаачдын

нийгэмлэгийн тэргүүн, хүмүүнлэгийн лектор Г.Бандицэрэнг урьж 2024 оны 05 дугаар сарын 13-ны өдөр нийт ард иргэд, төрийн албан хаагчид, сурагчдад “Амьдралын үнэ цэн”, “Үе тэнгийн дээрэлхэлт, сурч боловсрохын үнэ цэн” сэдвээр сургалт, лекц зохион байгууллаа. Тус сургалтад нийт 121 иргэд, Ерөнхий боловсролын сургуулийн 275 сурагчид хамрагдсан.

Мөн сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөх үйлчилгээнд тус сумын 6 иргэн хамрагдсан. Төрийн албан хаагчид, иргэдэд өгсөн сургалтаар “Амьдралын үнэ цэн” буюу хүн байхын учир, зөв мэдээлэл авч ашиглах, эерэг харилцаатай байхыг уриалсан ухааруулсан агуулгыг, сурагчдад үе тэнгийнхнээ ойлгох, нэгнийгээ хайрлахын учир холбогдол, зөв харилцааны талаар лекц, ярилцлага өрнүүлсэн. Иргэд болон сурагчид маш их зүйлийг ухаарсан сэтгэл ханамжтай сургалт болсон. Тус сургалт үйлчилгээг авах гэрээ байгуулан санхүүжилтийг Засаг даргын тамгын газраас шийдвэрлэн, сумын Үйлдвэрчний эвлэлийн хорооноос дэмжин хамтран ажиллалаа. Цаашид сумын хэмжээнд сэтгэл зүйч мэргэжилтэн ажиллуулах шаардлагатайг тус лектор зөвлөлөө. Гэр бүлийн хөгжлийг дэмжих жилийн ажлын төлөвлөгөөний хүрээнд гэр бүлд боловсрол олгох, сэтгэл зүйн болон харилцаа хандлагын талаар сургалт зохион байгуулахаар “Сэтгэлийн-Өнгө” сэтгэл зүйн төвийн үүсгэн байгуулагч, сэтгэл зүйч Г.Наранбаатартай хамтран ажиллах гэрээ байгуулан ажиллала. Сургалтаар хувь хүний хөгжил, харилцаа хандлага, гэр бүлийн харилцаа, хандлага, хүүхдээ хүмүүжүүлэхэд гэр бүлийн гишүүдийн харилцаа хандлага ямар байх ёстойг шинжлэх ухааны үндэслэлтэй тайлбарлан ойлгуулах агуулгаар 2 цагийн лекц сургалт зохион байгуулсан. Тус сургалтад нийт 116 иргэн, төрийн албан хаагч нар хамрагдаж багийн харьяаллаар 1-р багаас 20, 2-р багаас 43, 3-р багаас 28, 4-р багаас 25 иргэн хамрагдсан байна. Тус арга хэмжээний зардал төлбөрийг Засаг даргын нөөц хөрөнгөнөөс шийдвэрлэсэн. Сургалтад хамрагдсан иргэд, төрийн албан хаагчдын сэтгэл ханамж сайн байсан.

Оны онцлох гэр бүл шалгаруулах уралдаанд 5 гэр бүлий материал ирсэнээс Оюунлаг гэр бүл номинацид 1-р багийн иргэн Д.Энхдалай, спортлог гэр бүл номинацид 4-р багийн иргэн Ц.Шинэзориг, Хүмүүнлэг гэр бүлийн номинацид 4-р багийн иргэн Э.Золжаргал, Бүтээлч гэр бүлийн номинацид 3-р багийн иргэн Д.Дэлгэрдалайгийн гэр бүл шалгарч дараагийн шатны уралдаанд оролцуулахаар материалыг хүргүүлсэн. Шалгарсан гэр бүлүүдийг шагнаж урамшуулсан.

Хүүхдийн эрх оролцоог хангаж дэмжих үүднээс сургалт, урлаг, спортын арга хэмжээ,

1.“Одонгоо зүү ээжээ” эх үрсийн чуулган арга хэмжээнд сумын нийт одонтой ээжүүдийг урилгаар оролцуулж ээжүүдийн төлөөллөөс ахмад ээж, алдарт эхийн

хоёрдугаар одонт Ж.Мөнхжаргал “Залуу ээжүүддээ захиж хэлэх үг, эмэгтэй хүний эрхэм чанар” сэдвээр, хүүхдүүдийн төлөөллөөс 8-р ангийн сурагч М.Оюударь “Хүүхдүүдээ сонсоорой ээжүүдээ” сэдвээр тус тус илтгэл тавьсан. Тус арга хэмжээнд нийт 132 ээжүүд, хүүхдүүд хамрагдаж Алдарт эхийн хоёрдугаар одонг 8 ээжид гардууллаа. Мөн Гэр бүлийн боловсрол олгох “Угийн бичиг хөтлөх арга зүй”-н сургалтыг Засаг даргын тамгын газрын Нийгмийн бодлогын мэргэжилтэн өгсөн.

2. Ижийдээ бичих захидлын уралдаанд ирүүлсэн захидлыг ээжүүдэд нь уншиж танилцуулж шалгарсан захидлуудын эздийг шагнаж урамшууллаа.

3. Хүүхдийн баярыг угтан Соёлын төвөөс Хүүхдийн дууны уралдаан зохион байгуулж, хүндэтгэлийн концертыг Соёлын төвийн дэргэлдээ дугуйлангийн хүүхдүүд ээжүүд, хүүхдүүдэд танилцуулав.

4. Бага ангийн хүүхдүүдийн дунд унадаг дугуйн уралдаан, дунд ангийн хүүхдүүдийн дунд “Ураг удмаа мэдь” уриатай гар бөмбөгийн тэмцээнийг зохион байгуулж шалгарсан багуудыг шагнаж урамшуулав. Тэмцээн уралдаанд нийт 78 хүүхэд хамрагдсан байна.

5. Сумын хэмжээний зорилтод бүлгийн 79 хүүхдэд “Эрдэнэ Монгол” ХХК гарын бэлэг олгосон.

6. Хүүхдийн эрхийг хамгаалах өдрийг угтан сумын Цагдаагийн хэсгээс “Дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй” сургалтад 124 сурагч, Засаг даргын тамгын газраас “Мэргэжлээ сонгоё”, Өсвөр үеийн насны хүүхдүүдийн онцлог, Гэмт хэргээс урьдчилан сэргийлэх зэрэг сэдвүүдээр сургалт явуулж 126 хүүхэд хамрагдсан байна. Мөн тус сургалтын үеэр хүүхдүүдээс хүүхдийн баяраар зохион байгуулах ажлын саналыг авч хөтөлбөрт тусгасан.

“Хүүхдээ сонсох өдрийг сар бүр зохион байгуулж хүүхдүүдээс гарсан саналыг төлөвлөгөөнд тусган хэрэгжүүлж ажиллалаа. Үүнд: Сургуулийн ногоон байгууламжийг нэмэгдүүлэх саналыг хүлээн авч төгсөх ангийн сурагчид сургууль орчмын бүс болон сум орон нутгийн мод тарих ажилд оролцон Б.Булганаа багштай 9а бүлэг 30 мод тарисан. Номын сангийн үйл ажиллагааг эрчимжүүлж уншлагын хуваарь гарган ажиллаж байна. Сүүлийн жилүүдэд номын баяжилт хийх төсөв тавигдахгүй байна. Охидын өрөөтэй болох ажлын төлөвлөлт хийсэн, Тоглоомын талбайг тохижуулах, аюулгүй байдлыг хангах үүднээс сандал зэргийн будгийг сэргээж эвдэрч хэмхэрсэн тоглоомыг сэргээн засварласан. Биеийн тамирын хичээлийн бөмбөг, бусад хими, физик зэрэг хичээлүүдийн аюулгүй ажиллагааны хэрэглэгдэхүүнийг хүртээмжийг нэмэгдүүлэх саналын хэрээнд хичээл практикийн

зардлаас нэмэлт баяжуулалт хийгдэж байгаа. / Эко кабинетийн хэрэглэгдэхүүнийг байгалийн ухааны хичээлүүдээр ашиглах боломжтой болсон. Шинэ сурах бичгийн хангамжийг нэмэгдүүлэхэд 1-4 дүгээр анги хамгийн сүүлд хэвлэгдсэн /2019 оны / сурах бичгийг 100% ашиглаж байна. Ирэх хичээлийн жилээс дунд анги 100% түрээсийн сурах бичиг ашиглана. Анхан шатны тусламж үзүүлэх шаардлагатай эмийн сан байршуулж кабинет бүр анхан шатны тусламжийн хайрцаг, эмийн сантай болсон. Сургууль дотор шаардлага хангасан худалдааны буфеттэй болох санал гарсан бөгөөд энэ талаар судалгаа хийж байна. Дүрэмт хувцасны энгэрт өөрийн сум сургуулийн логотой болох санал гарсаныг судлаад 2024 оны 09 дүгээр сарын 01 нээс сургуулийн сурагчдын дүрэмт хувцасны энгэрт лого хийлгэхээр болсон. Гадна ариун цэврийн байгууламжийг ажиллагаанд оруулах саналын хувьд сурагчдын амралтаар үйлчилгээний ажилчид хулдаасаар доторлон банзнуудыг хадаж засварлаж ариутгасан. Сургууль доторх ариун цэврийн байгууламжийг ажиллагаанд оруулах саналаар сумын онцгой комисст хандан цэвэрлэх байгууламжийн насосыг шийдвэрлүүлж хөлдсөн хэсгийг олж гэсгээн үйл ажиллагааг хэвийн болгосон. Хичээлээс гадуурх дугуйлан секцийн тоог хүүхдүүдийн сонирхолд нийцүүлэн нэмэгдүүлэх, сонирхон дугуйландаа хүүхдүүд бүрэн хамрагдах боломжийг бүрдүүлэх саналын хувьд хичээлийн жилийн эхэнд сурагчдаас санал авч 12 дугуйлан хичээллэж байна. Сургууль дотор эрүүл ахуйн шаардлага хангасан ус уух боломжийг бүрдүүлэх саналаар цэвэр усанд холбогдоогүй цэвэрлэх төхөөрөмж суурилуулах боломжгүй учир их завсарлагаанаар анги танхимдаа цай уух боломжыг бүрдүүлсэн. Үе тэнгийн дээрэлхэлтийн талаар сургалт нөлөөллийн ажил зохион байгуулах саналаар Хүүхэд гэр бүл залуучуудын хамгааллын газартай хамтран өсвөр үе, үе тэнгийн дээрэлхэлтийн талаар сургалт зохион байгуулсан. Мөн лектор Г.Бандицэрэнг урьж 5 сарын 13-нд сургалт зохион байгуулсан. Тус сургалтад 215 сурагч хамрагдсан. Сурагчдын дунд дээрэлхэлт дэлгэрэх ёсгүй аянаар сурагчдад болон эцэг эхчүүдэд үе шаттай сургалтуудыг зохион байгуулсан.

Машины зогсоолд машинаа байрлуулах шаардлага тавьж хэвшүүлэх саналаар Сумын гэмт хэргээс урьдчилан сэргийлэх салбар зөвлөлтэй хамтран хууль эрх зүйн сургалт явуулж байгууллагын албан хаагчид машинаа байгууллагын зогсоол спорт залны зогсоолд машинаа байрлуулдаг болсон. Нохой устгал хиймээр байна гэсэн саналын хүрээнд сумын хэмжээнд 4 дүгээр улиралд нохой устгал хийгдсэн. Хүүхдээ сонсох өдөр арга хэмжээнд Засаг даргын тамгын газар, Эрүүл мэндийн төв, Цагдаагийн хэлтэсээс удирдах албан тушаалтан хүмүүсийг суулгах саналын дагуу Хүүхдээ сонсох өдөр арга хэмжээнд сумын Засаг дарга, Нийгмийн

бодлогын мэргэжилтэнийг урьж оролцуулан хүүхдүүдтэй санал бодлоо солилцсон байна.

Байгууллагын 2024 оны Хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн төлөвлөгөөний дагуу эрсдлийн үнэлгээг хийлээ. Тус үнэлгээнд байгууллагын 36 албан хаагч, тэдгээрийн ажлын байрны 13 өрөө тасалгаатай танилцан, судалгаа санал асуулга авч нэгтгэлээ. Тус судалгаагаар:

1. ХАБЭА-н сургалтад албан хаагчдын 60 хувь нь хамрагдсан.
2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх эрт илрүүлгийн үзлэгт 31.5 хувь хамрагдсан.
3. Ажлын байран дахь тавилга тоног төхөөрөмжийн хангалт сайн боловч зарим тоног төхөөрөмжийг шинэчилж хангах шаардлагатай байна.\хавсралтаар\
4. Ажлын байрны физик хүчин зүйлүүдийн шаардлагын хангалтын байдлаар цахилгааны аюулгүй байдал хангагдаагүй, гэрэлтүүлгийн нөхцөл байдал тааруу, зарим өрөөнүүдийн дулааны зөвшөөрөгдөх хэмжээ хангагддаггүй гэж гарсан.

Мөн Баянцагаан сум дахь Эрэн хайх, аврах бүлгийн даргаар ахлуулсан баг 2024 оны 01 дүгээр сарын 29-нд тус байгууллага дээр шалгалт хийж холбогдох зөвлөгөө өгсөн. Тус шалгалтын зөвлөгөө болон дээрх судалгааны дүгнэлтийн хүрээнд дараах арга хэмжээг авч байгууллагын нийт албан хаагчдын ажиллах нөхцөл буюу хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах шаардлагатай байна.

1. ХАБЭА-н сургалтыг зохион байгуулж албан хаагчдыг бүрэн хамруулах.
2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаагүй албан хаагчдыг эрт илрүүлгийн үзлэгт бүрэн хамруулах арга хэмжээ авах
3. Албан хаагчдын ажлын байран дахь солих шаардлагатай тоног төхөөрөмж, тавилгыг шинэчлэх
4. Албан хаагчдын ажлын өрөө тасалгаануудын цахилгааны аюулгүй байдлыг хангаж цахилгааны монтажыг солих, далдлах, разетик, шийтүүдийг солих бүх өрөөнүүдийн гэрэлтүүлгийг MNS6767:2019 стандартад нийцүүлэн сольж шинэчлэх, зарим өрөөнүүдийн дулаан алдагдлыг багасгах, багийн дарга нарын өрөөнд халаалтын систем байрлуулах
5. Байгууллагын галын хорын нөөцийг бүрдүүлэх, галын аюулгүй байдлын буланг шинэчлэн байршуулах, дутуу багажнуудыг бүрдүүлэх, хариуцах эзэнтэй болгох

6. Байгууллагын цахилгааны шийтүүдийг цоожтой болгож түлхүүрийг хариуцуулах

6. Албан хаагчдын ус уух боломжийг бүрдүүлэх

7. Албан хаагч нарт анхны тусламж өгөх чадвар олгох сургалтад хамруулж, анхны тусламжийн багц бүрдүүлж байршуулах, хариуцуулах

8. Нярав, үйлчлэгч нарыг ажлын тусгай хувцасаар хангах

9. Архивын өрөөг стандарт шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр тохижуулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна.

Дээрх арга хэмжээг хэрэгжүүлэх төсөв санхүүг шийдвэрлэх талаар байгууллагын даргад танилцуулсан.

Байгууллагын нийт албан хаагч нарт Хөдөлмөрийн аюулгүй байдлын тухай хууль, мэргэжлээс шалтгаалах өвчлөл түүнээс урьдчилан сэргийлэх чиглэлээр сургалт өгсөн. Албан тасалгаануудыг цэцэгжүүлэх аяныг өрнүүлэн ажиллаж байна.

Мөн Эрт илрүүлгийн үзлэгт хамрагдаагүй 23 албан хаагчийг 2024 оны 04 дүгээр сарын 29-30-ны хооронд аймгийн эрүүл мэндийн төвд хамруулсан.

9. Хамтарсан багийн ажлын талаар: 2024 оны эхний хагас жилийн хугацаанд хамтарсан багийн төлөвлөгөөт хурал 4 удаа, шуурхай хурал 1 удаа зохион байгуулж холбогдох асуудлаар шийдвэр гаргаж ажиллалаа.

Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 4 кейс нээн ажиллаж байна. Гэр бүлийн нөхцөл байдлын судалгааг хийж холбогдох арга хэмжээг авч ажилласан.

Суурь судалгаануудыг чиглэл бүрээр гаргаж судалгаа мэдээллийн сан бүрдүүлсэн.

5 сарын 5-аас оройн цагаар эргүүл, жижүүр хийж тэмдэглэл хөтлөн баталгаажуулсан бөгөөд ноцтой зөрчил илрээгүй, оройн цагаар гадуур яваа хүүхдүүдэд гэртээ харих шаардлага тавьж ажилласан байна. Мөн спорт заалны үйлчилгээг үзүүлэхдээ орой 19 цагаас хойш хүүхдүүдэд цаг өгөхгүй байхыг зөвлөсөн. Машин, мотоцикль унадаг хүүхдүүдийн судалгаа гаргаж сануулга, хууль эрх зүйн сургалтыг өгсөн.

Хүмүүнлэгийн сэтгэл зүйч Г.Бандицэрэнг урьж "Амьдралын үнэ цэн", "Үе тэнгийн дээрэлхэлт" сэдвээр сургалт зохион байгуулсан бөгөөд 6 хүнд сэтгэл зүйн ганцаарчилсан зөвлөгөө өгсөн. Тус сургалтад 96 иргэн, 243 сурагч хамрагдсан.

Хамтарсан багийн гишүүд Хууль эрх зүйн холбогдох чиглэлүүдээр нийт 12 сургалтыг 1740 иргэдэд зохион байгуулсан.

Эмэгтэйчүүдийн эрхийг хамгаалах өдрөөр тусгай удирдамжийн дагуу чуулган, сургалт, уралдаан тэмцээнүүдийг зохион байгуулсан. Тус арга хэмжээнд 180 гаруй

эмэгтэйчүүд хамрагдсан Мөн цэргийн баяраар эрчүүдэд дартс хөгжөөнт буухиа, волейболын тэмцээнүүдийг тус тус зохион байгуулж нийт 60 иргэн хамрагдсан. Дээрх арга хэмжээнүүдийн хүрээнд хууль эрх зүй, гэмт хэрэг зөрчлөөс урьдчилан сэргийлэх, гэр бүлийн болон хүүхдийн хүчирхийллийн эсрэг хууль эрх зүйн мэдлэг олгох сургалтуудыг зохион байгуулсан.

Хамтарсан багийн дарга, нарийн бичгийн дарга нарын санаачлагаар Ерөнхий боловсролын сургуулийн нийт сурагчдад Хамтарсан багийг танилцуулах, Хүүхдийн эрх хамгааллын үйлчилгээ, холбогдох мэдээллүүдийг “Хүүхдээ сонсох өдөр” арга хэмжээний үед өгч хүүхдүүдийн саналыг сонсож харилцан санал бодлоо хуваалцсан.

Хүүхдийг зодож шийтгэхийн эсрэг өдрийн хүрээнд иргэдэд мэдээлэл өгч /37 иргэн хамрагдсан/, Хүүхдийн эрхийн тухай хуулийн сургалт зохион байгуулсан.

Архины хамааралтай иргэдийн судалгааг гаргаж Жаргалтай амьдрал төвийн үйлчилгээнд хамрагдах саналыг тавьж танилцуулсан боловч хуваарьт хугацаанд нэг ч иргэн хамрагдсангүй.

Байгууллагуудын эцэг эхийн зөвлөлийн гишүүдэд жилийн үйл ажиллагааны төлөвлөгөө танилцуулж эцэг эхийн зөвлөлийн ажиллах журам, төлөвлөгөөний загварыг танилцуулан төлөвлөгөөнд тусгах асуудлуудаа хэлэлцсэн. 50 эцэг эх хамрагдсан. Шилдэг эцэг эх шалгаруулах болзлыг танилцуулсан. Шилдэг эцэг эхийн зөвлөл шалгаруулах болзолд төрийн байгууллагууд материалаа хүргүүлсэн.

1. Хүний эрхийн зөрчил 1-5 жил үргэлжилж байгаа

Эрдэнэ Монгол ХХК-ний Баянхөндий төсөл нь Шинэжинст сумын Уртын гол 2 дугаар багийн нутаг дэвсгэрт 2010 оноос 2024 оны 12 дугаар сар хүртэл хугацаанд Алтны чиглэлээр үйл ажиллагаа явуулж байгаа бөгөөд бүтээн байгууллалтууд хийгдэж том машинууд, ажилчдын машинууд гээд олон машин явж байгаагаас үүдэн зам эвдэрч, тоосжилт үүсч хур бороо орохоо байж мал, ань амьтаны усны хүрэлцээ муу болсон иргэдийн эрүүл аюулгүй орчинд амьдрах эрх зэрэг эрхүүд ноцтойгоор зөрчигдөж байна. Уг компаний үйл ажиллагааг эсэргүүцэн Нутгийн төрийн бус байгууллага дээд байгууллага хүртэл нь мэдэгдэж үйл ажиллагааг нь зогсоож өгөхийг хүсэж явсан боловч ажилт олоогүй мөн тус компаний захирал, төлөөлөгч нартай олон удаа уулзсан хууль ёсны зөвшөөрөлтэй гэдэг тайлбар тавин үйл ажиллагаагаа хэвийн явуулж байна. Тус компани үйл ажиллагаагаа явуулсаар байвал тухайн бүсэд байгаа нутаг дэвсгэр, наашлаад малчин ард иргэд, мал, ан амьтдын эрх, зөрчигдөхөөр байна.

Мөн Уртын гол 2 дугаар багийн нутаг дэвсгэрт буюу сумын төвөөс 10 гаран км зайд байрлах Хотгорын нүүрсний уурхай үйл ажиллагаагаа явуулах бэлтгэл ажлыг хангаад байна. Тус нүүрсний уурхайн сумын төвөөс холгүй, баруун дээд зүгт буюу сахин дээр байрладаг бөгөөд үйл ажиллагаа явуулж эхэлснээр сумын нийт 2000 гаруй иргэдийн эрх зөрчигдөн. Жил бүрийн 11 сарын сүүл 12 сарын эхээр айл өрх болгонд өвлийн бэлтгэлийг хангах зорилгоор тонн нүүрсийг олгодог. Нутгийн ард, иргэд, ТББ-ууд үйл ажиллагааг нь эсэргүүцэж компани төлөөлөл, төрийн байгууллагуудад өргөдөл хүсэлт өгсөнч боловч үйл ажиллагаа явуулахаар бэтгэл ажлаа хангаад бүтээн байгуулалт хийдэг байна.

2. Санал дүгнэлт

Сумын нутгийн удирдлага буюу төрийн захиргааны байгууллагын нийт албан хаагчдын ажиллах нөхцөл буюу хөдөлмөрийн аюулгүй байдал эрүүл ахуйн шаардлагыг хангаж ажиллах шаардлагатай байна.

1. ХАБЭА-н сургалтыг зохион байгуулж албан хаагчдыг бүрэн хамруулах.
2. Эрүүл мэндийн урьдчилан сэргийлэх үзлэгт хамрагдаагүй албан хаагчдыг эрт илрүүлгийн үзлэгт бүрэн хамруулах арга хэмжээ авах
3. Албан хаагчдын ажлын байран дахь солих шаардлагатай тоног төхөөрөмж, тавилгыг шинэчлэх
4. Албан хаагчдын ажлын өрөө тасалгаануудын цахилгааны аюулгүй байдлыг хангаж цахилгааны монтажыг солих, далдлах, разетик, шийтүүдийг солих бүх өрөөнүүдийн гэрэлтүүлгийг MNS6767:2019 стандартад нийцүүлэн сольж шинэчлэх, зарим өрөөнүүдийн дулаан алдагдлыг багасгах, багийн дарга нарын өрөөнд халаалтын систем байрлуулах
5. Байгууллагын галын хорын нөөцийг бүрдүүлэх, галын аюулгүй байдлын буланг шинэчлэн байршуулах, дутуу багажнуудыг бүрдүүлэх, хариуцах эзэнтэй болгох
6. Байгууллагын цахилгааны шийтүүдийг цоожтой болгож түлхүүрийг хариуцуулах
7. Албан хаагчдын ус уух боломжийг бүрдүүлэх
8. Албан хаагч нарт анхны тусламж өгөх чадвар олгох сургалтад хамруулж, анхны тусламжийн багц бүрдүүлж байршуулах, хариуцуулах
9. Нярав, үйлчлэгч нарыг ажлын тусгай хувцасаар хангах
10. Архивын өрөөг стандарт шаардлага хангасан тоног төхөөрөмжөөр тохижуулах зэрэг арга хэмжээ авах шаардлагатай байна. Гэр бүлийн хүчирхийлэлтэй холбоотой 4 кэйс гарсан байгаан гэр бүлийн харилцаа хандалага, цаашлаад

хүүхдийн эрх хөндөгдөж зөрчигдөхөөр байгаа тул сумын Хамтарсан баг, Цагдаагийн тасаг хамтран ажиллах шаардлага гарч байна. Иймд 2025 оны 01 сараас эхлэн Хамтарсан баг, Цагдаагийн тасгийн үйл ажиллагааг сайтар холбон гэр бүлийн хүчирхийлэл, хүүхэдрүү илүү чиглүүлж төлөвлөгөөг боловсруулан ажиллах шаардлагатай гэж дүгнэж байна. Мөн сумын төвд амиа хорлох гэмт хэрэг удаа дараа он сарын давдамжтай гарч байгаа нь соён гэгээрүүлэх үйл ажиллагаа тутмаг, гэмт хэргээс урьдчилан сэргийлэх үйл ажиллагаа муу байна гэж үзэж байна.

Төрийн байгууллагаас ард иргэдэд сургалт, мэдээллийг олон удаа хийхийг зорьдог боловч хамрагдах хүний тоо маш бага байдаг.

ХЯНАСАН
ЗАСАГ ДАРГА

Л.БАТХУЯГ

ТАЙЛАН БИЧСЭН
ХУУЛЬ, ЭРХ ЗҮЙН АСУУДАЛ ХАРИУЦСАН
МЭРГЭЖИЛЭН У. Наранцэцэг Ц.НАРАНЦЭЦЭГ